

Rio Tinto

Мэдээллийн хуудас

Компанийн танилцуулга





Рио Тинто компани нь газрын хэвлий дэх эрдэс баялгийн эрэл хайгуул, олборлолт, ашигт малтмалын баяжуулалт зэрэг чиглэлээр дэлхийд тэргүүлэгч юм. Манай бүтээгдэхүүнүүд хэрэглэгчдийн чухал хэрэгцээг хангаж, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд тус дөхөм болдог.

Төрөл бүрийн металл, эрдэс баялгаар цангасан дэлхийн хэрэгцээг хангахад шаардагдах боловсон хүчин, чадавхи, нөөц боломж бидэнд бий. Бид бүхий л үйл ажиллагааныхаа туршид хөдөлмөрийн аюулгүй байдал, өндөр хариуцлага, тогтвортой байдлыг бүрэн хангаж ажилладаг.

Дэлхийн 40 гаруй улс орны 77,000 орчим ажилтнуудын мэдлэг, ур чадвар, ажлын туршлага, хувийн шинж чанаруудыг нэгтгэж хамтатгасан боловсон хүчин маань бидний амжилтын үндэс болдог. Ард иргэд, засгийн газрууд, ажиллагсад болон хөрөнгө оруулагчид зэрэг бүх түншүүдтэйгээ байнгын харилцаа холбоотой байх замаар бид итгэлцлийн харилцаа бий болгож, бизнесийн болон техникийн бэрхшээлүүдийг шийдвэрлэж, нийгмийн тогтвортой хөгжил рүү шилжих үйл явцад хувь нэмрээ оруулдаг.

Зүүн гарт

Төрөл бүрийн металл, эрдэс баялгаар цангасан дэлхийн хэрэгцээг хангахад шаардагдах боловсон хүчин, чадавхи, нөөц боломж бидэнд бий.



Рио Тинто компани нь газарзүйн болон үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний хувьд өргөн цар хүрээг хамардаг. Бид ил ба далд уурхай, тээрэмдэх, боловсруулах, хайлуулах үйлдвэрүүд эзэмшдэгийн сацуу судалгаа шинжилгээ, үйлчилгээний хэд хэдэн төвийг ажиллуулдаг. Манай компани хөнгөн цагаан, зэс, алмааз, нүүрс, төмрийн хүдэр, уран, алт, мөн аж ахуйн ашигт малтмалууд (борын хүчлийн давс, титаны давхар исэл, давс, тальк) зэрэг гол бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг юм.

Бид эрс тэс уур амьсгал бүхий хамгийн хүнд нөхцөлтэй газар нутгуудад ажилладаг. Компаний үйл ажиллагаа Австрали болон Хойд Америкт голлон төвлөрдөг ч Европ, Өмнөд Америк, Ази болон Африкт бас үйл ажиллагаа явуулдаг.

Манай компани өөр бусад компаниудыг худалдаж авах замаар түргэн өсөж томорсны дотор хамгийн онцлууштай нь 2007 онд Алкан Инк. компанийг худалдаж авсан явдал юм.

Бид аливаа зүйлд ёс суртахуунтай, хариуцлагатай ханддаг нь бизнест сайнаар нөлөөлж, ажилтан, ажилчдын итгэл үнэмшилд тусгалаа олдог. Аливаа сайн үйлийг сайн нэр хүнд дагалддаг. Нэр хүндтэй байх нь амжилтанд хүрэхэд шаардагдах эрдэс баялаг, санхүүгийн болон хүний нөөцөд илүү хүрч ажиллахад тус дөхөм болдог. Мөн, хөрөнгө оруулагчдын ашгийг нэмэгдүүлж, ажилчдаа илүү өндөр цалин урамшуулалтай ажлын байраар хангах боломжийг олгодог.

Рио Тинтогийн дэлхий хэмжээнд баримталдаг бизнесийн ёс зүйн дүрмийг *Бидний ажилладаг арга барилд* тодорхойлсон болно. Уг дүрэмд компанийн нийгмийн хариуцлагын амлалтыг дахин баталгаажуулах ёс зүйн зарчим, стандартууд багтсан байдаг.

Бидний ажилладаг арга барилд тодорхойлогдсон үйл ажиллагааны стандартууд нь Рио Тинтогийн үндсэн дөрвөн үнэт зүйлс болох “Хариуцлага”, “Хүндлэл”, “Хамтын ажиллагаа”, “Шударга байдалд” тулгуурладаг.

Рио Тинтогийн мөн чанар бол аливаа ажлыг “зөв хийх” гэсэн бидний хүсэл эрмэлзэл юм. Бид хийж байгаа ажилдаа анхаарлаа бүрэн хандуулж ажилладаг билээ. Дэлхийн хамгийн их амжилтанд хүрсэн компаниудын нэг болохын хувьд бид уул уурхайгаас бусад салбарт ч танигдсан билээ.

Бид уул уурхайн салбарт 130 гаруй жил үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд бидэнд бахархах түүх, өв уламжлал бий.

Компани бий болсон түүх

Рио Тинтогийн өвөг компаниуд болох Рио Тинто Компани ба Консолидэйтэд Цинк Корпорейшн нь 1873, 1905 онуудад тус тус үүсгэн байгуулагдаж байжээ.

Рио Тинто Компани нь өмнөд Испанид орших Рио Тинто гэх газраас зэс олборлох зорилгоор Лондонд байгуулагджээ. Энэ уурхай нь эрт дээр үед Ромын эзэнт улсыг зэсээр хангаж байсан түүхтэй. Рио Тинто гэдэг нэр нь уурхайн ойролцоо урсдаг “өнгөт гол” нэрээс үүдэлтэй ажээ.

Консолидэйтэд Цинк Корпорейшн нь Австралийн Брокен Хиллзд байрлах цайр агуулсан уурхайн хог хаягдлыг шүүж ялгахар байгуулагдаж байжээ.

1962 онд дээрх хоёр компани нэгдэж Рио Тинто Цинк Корпорейшн (RTZ Corporation) болжээ. Мөн үед Австрали дахь охин компаниудыг нэгтгэж Концинк Рио Тинто Австрали Лимитед (Conzink Riotinto Australia/CRA Limited) компани байгуулагдсан. 1995 онд RTZ болон CRA компаниуд хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй компанийн бүтэц зохион байгуулалттайгаар нэгджээ. 1997 онд RTZ нь Рио Тинто плс нэртэй болж, харин CRA нь Рио Тинто Лимитед болж хамтдаа Рио Тинто Групп нэрийн дор нэгджээ.

Рио Тинто бизнес эрхлэхдээ охин компаниуд болон ажиллагсдынхаа туршлага, үүрэг хариуцлагад тулгуурлан дэлхийг хамарсан чиг хандлагыг баримталдаг. Бид нийтлэг үнэт зүйлс, бодлого, стандарт болон зарчмуудтай бөгөөд группийн хэмжээнд хамгийн шилдэг туршлагыг хуваалцаж ажилладаг нь байнга ашиг тусаа өгч байна.

Бид уул уурхайн салбарт 130 гаруй жил үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд бидэнд бахархах түүх, өв уламжлал бий.

Стратеги

Рио Тинтогийн зорилго нь байгалийн баялгийг хайж илрүүлэх, олборлох, боловсруулах үйл ажиллагааг тогтвортой явуулах замаар хувьцаа эзэмшигчдэд очих үр ашгийг нэмэгдүүлэхэд оршдог. Бидний стратеги бол ашигт малтмалын аль нэг төрлийг сонгохдоо биш, харин аливаа боломжийн чанарыг харгалзан урт удаан хугацаанд өрсөлдөхүйц өртгөөр ажиллуулах боломжтой томоохон уурхайнуудад хөрөнгө оруулж, ашиглах явдал юм.

Манай групп дээрх стратегийг хэрэгжүүлэхийн тулд дараахь зүйлс дээр анхаарлаа төвлөрүүлдэг:

- Нэгдүгээр зэрэглэлийн (өртөг багатай, их хэмжээний) ордыг илрүүлэх нь бидний ирээдүйн үр ашгийг баталгаажуулдаг;
- Группийн эзэмшлийн орд газруудыг найдвартай, үр ашигтай, урт хугацаагаар бага өртөгтэй ашиглах нь ашигт матмалын эрэлт хэрэгцээ ба нийлүүлэлт, үнийн хэлбэлзлээс үл хамааран ашигтай ажиллахыг баталгаажуулдаг;
- Ёс суртахуунтай, нийгмийн бариуцлагатай үйл ажиллагаа нь Рио Тинтогийн нэр хүндийг ямагт өндөрт өргөж, боловсон хүчний нөөц, хөрөнгө санхүү, эрдэс баялгийг тогтвортой ашиглах явдлыг баталгаажуулж өгдөг;
- Урт хугацааны тогтвортой хөгжлийг Группийн бүх үйл ажиллагааны үндсэн шалгуур болгож үздэг.

Удирдлагын бүтэц

Рио Тинто Групп нь Лондонд төвтэй, Лондонгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Рио Тинто плс болон Мельбурнд төвтэй, Австралийн үнэт цаасны биржид бүртгэлтэй Рио Тинто Лимитэд компаниудаас бүрддэг. Компанийн хувьцааг Лондонгийн хөрөнгийн бирж, Австралийн үнэт цаасны биржээр борлуулдаг, мөн Нью-Йорк, Шинэ Зеланд, Европт арилжаалдаг.

Рио Тинто нь дангаар болон хэсэгчлэн эзэмшдэг охин компаниуд, хамтран эзэмшдэг орд, уурхай болон хамтарсан компаниудаас бүрддэг.

Рио Тинто нь Хөнгөн цагаан, Зэс, Алмааз ба Эрдэс, Эрчим хүч, Төмрийн хүдэр зэрэг үндсэн бүтээгдэхүүн хариуцсан таван бүлэг, мөн Технологи-Шинэчлэлт, Хайгуул зэрэг хоёр туслах бүлгээс бүрддэг.

Зүүн талд

Манай гол бүтээгдэхүүнд төмрийн хүдэр, хөнгөн цагаан, зэс, алмааз, нүүрс, уран, алт болон аж ахуйн ашигт малтмалууд багтдаг.

Бүтээгдэхүүн хариуцсан бүлгүүд

Хөнгөн цагаан

Рио Тинто Алкан бол хөнгөн цагаан бүтээгдэхүүнийг хариуцсан бүлэг бөгөөд энэ чиглэлээр дэлхийд тэргүүлэгч юм. Уг бүлэг нь тухайн салбартаа хамгийн сүүлийн үеийн технологи бүхий хайлуулах үйлдвэртэй бөгөөд өндөр чанарын хөнгөн цагааны хүдэр (боксит) олборлоод анхдагч хөнгөн цагааны үйлдвэрлэл ба хөнгөн цагааны ислийг дагнасан зах зээлд зориулж хөнгөн цагааны исэл гарган авч, анхдагч хөнгөн цагааныг хамгийн бага өртгөөр үйлдвэрлэдэг юм.

Тус бүлэг нь зуу гаруй жилийн хугацаанд хуримтлуулсан туршлага, мэдлэгтэй тулгуурлан зах зээлийн тэргүүлэх байр сууриа шинжилгээ судалгаа, технологи болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээр баталгаажуулдаг.

Рио Тинто Алкан нь дэлхийн таван тивд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд ихэнх уурхайнууд Канад, Австрали, Франц болон Англид төвлөрдөг.

Уг бүлэг нь Хөнгөн цагааны хүдэр ба исэл, Үндсэн Металл - Хойд Америк, Үндсэн Металл - Европ, Ойрхи Дорнод, Африк, мөн Үндсэн металл - Номхон далай гэсэн бизнесийн дөрвөн нэгжээс бүрддэг.

Алкан Инк нь 2007оны аравдугаар сарын 23-нд Рио Тинто групптэй нэгджээ.

Зэс

Рио Тинтогийн Зэсийн бүлэг нь зэсийн үйлдвэрлэлийн чиглэлээр дэлхийд тэргүүлэгч юм. Америкийн Кеннекотт Ютагийн уурхайг эзэмшдэгээс гадна Чилийн Эскондида, Индонезийн Грасберг, Австралийн Нортпаркс болон Өмнөд Африкийн Палаборагийн уурхайнуудад хувь эзэмшдэг.

2009 онд энэ бүлэг ойролцоогоор 800,000 тонн зэс боловсруулж дэлхийн таван том зэс боловсруулагч компаниудын нэг болсон. Алт болон молибден нь тус бүлгийн уурхайнуудын хүнэт дайвар бүтээгдэхүүнүүд юм.

Өөрийн ашиглаж байгаа уурхайнуудаас гадна шинээр олж тогтоосон, ашиглагдаагүй байгаа дэлхийн хамгийн том зэсний гурван төсөлд хувь эзэмшдэг. Мөн, АНУ болон Индонезид никелийн томоохон ордыг эзэмшдэг.

Алмааз & Эрдэс

Рио Тинто нь дэлхийн томоохон алмааз үйлдвэрлэгчдийн нэг бөгөөд байгалийн өнгөтэй алмааз боловсруулалтаараа дэлхийд дээгүүр ордог. Рио Тинто нь Канад дахь Дайвик, Австрали дахь Аргайл, Зимбабвегийн Мурова уурхайг эзэмшдэг мөн Энэтхэгийн Мадья Прадеш дахь алмаазын төсөлд хувь оролцоотой.

Рио Тинтогийн алмааз эрдэнийн худалдаа, маркетингийн үйл ажиллагаа нь Лондонд төвлөрдөг бөгөөд дэлхийн алмаазын төв болох Бельгийн Антверпен хотод төлөөлөгчийн газартай. Бүртгэл, тээвэрлэлт, хадгалалтын дүрэм журмыг чандлан баримталдаг нь бүтээгдэхүүн бүрийн гарал үүслийг тогтооход маш амархан байдаг.

Рио Тинтогийн үйлдвэрлэлийн эрдсийн хэсэг нь Хойд ба Өмнөд Америк, Европ, Австрали, Азид борын хүчлийн давс болон тальк үйлдвэрлэдэг Рио Тинто Минералз мөн Хойд Америк, Өмнөд Африк болон Мадагаскарт үйл ажиллагаагаа явуулдаг Рио Тинто Төмөр ба Титан хэсгүүдээс бүрддэг.

Үйлдвэрлэлийн эрдсийн салбарын зах зээлийн хуваарилалт нь техникийн болон маркетингийн сайн мэдээлэл, судалгаанаас ихээхэн шалтгаалдаг тул Рио Тинто компани шинэ бүтээгдэхүүн бий болгох, хэрэглэгчдийг дэмжихэд чиглэгдсэн судалгаа, туршилтын төвүүдийг Европ, Канад, АНУ-д ажиллуулдаг.

Дээр

Канадын Дайвикийн очир алмаазын уурхай руу хөтлөх мөсөн зам.



Үйл ажиллагааг дэмжих бүлэг

Эрчим хүч

Эрчим хүчний бүлэг нь нүүрс, коксжсон нүүрс болон уран боловсруулах үйл ажиллагаа явуулдаг.

Рио Тинто нь нүүрс, коксжсон нүүрсийг далайгаар тээвэрлэн Азийн зах зээлд нийлүүлдэг.

Австрали, АНУ дахь манай нүүрсний уурхайнууд Австрали, АНУ-ын дотоодын зах зээлийг хангахаас гадна далайгаар тээвэрлэж борлуулдаг. Рио Тинто Коул Австрали нь Күинсланд болон Нью Саутс Уэлс мужийн нүүрсний найман уурхай дахь Группын хувь эзэмшлийг удирдан ажилладаг.

Рио Тинто нь мөн АНУ-ын Колорадо байдаг Коловьё ил нүүрсний уурхайг эзэмшдэг ба АНУ-гийн Вайоминг болон Монтана муж дахь Клауд Пийк Энэржигийн 48 хувийг эзэмшдэг.

Одоогийн ашиглаж байгаа Күинсланд мужид байдаг Хэйл Крик ба Хантер Валлэй нүүрсний уурхай дахь Коул энд Эллайд үйл ажиллагааг өргөтгөх хэд хэдэн боломж байгаа бөгөөд Рэнжер болон Рессинг ураны уурхайнуудын өргөтгөлийг судалж байгаа.

Рио Тинто нь дэлхийд тэргүүлэгч уран үйлдвэрлэгчийн нэг бөгөөд дэлхийд хоёр болон гуравт ордог ураны томоохон уурхайг ажиллуулдаг. Ихэнх хувийг нь эзэмшдэг Австрали, Намиб дахь уурхайнуудаас олборлосон ураны ислээр олон орны атомын цахилгаан станцуудыг хангадаг.

Төмрийн хүдэр

Төмрийн хүдрийн бүлэг нь Австрали дахь Хамерсли Айрон болон Роуб Ривэр Төмрийн Холбоо, Канад дахь Төмрийн хүдэр компани, мөн Австрали дахь төслүүд, Гвинейн Симандоу, Энэтхэгийн Орисса уурхайнуудыг эзэмшдэг. Австралийн Хайсмелт Дайрект төмрийн үйлдвэр энэ бүлэгт багтдаг.

Рио Тинтогийн төмрийн хүдрийн уурхайнууд нь Азийн хэрэгцээг хангах газар зүйн давуу байрлалтай төдийгүй, дэд бүтэц сайн хөгжсөн Баруун Австралийн Пилбара бүс нутагт орших үйлдвэрлэлийн бүсэд ойрхон асар их хэмжээний нөөцтэй.

Төмрийн хүдрийн бүлэг нь Пилбарагийн төмрийн хүдрийн уурхайн ойролцоо байдаг давс болон шохойн Дампир Солт ордын үйл ажиллагааг давхар хариуцдаг.

Их хэмжээний далайн тээвэрлэлтийн үйлчилгээний томоохон хэрэглэгчийн хувьд Төмрийн хүдрийн бүлэг нь төмрийн хүдэр болон Рио Тинто компанийн бусад овор ихтэй бүтээгдэхүүнийг тээвэрлэдэг Рио Тинто Марин компанийг хариуцан ажилладаг.

Төслүүд болон ашиглагдаж буй уурхайнуудаа өргөжүүлснээр Рио Тинтогийн Төмрийн хүдрийн бүлэг нь өөрийн салбартаа тэргүүлэх байр сууриа хадгалах, өргөжүүлэх зорилготой ажилладаг.

Технологи ба Шинэчлэлт

Технологи, Шинэчлэлт (T&I) бүлгэм нь Австрали, Канад, Англи болон Америкт төвлөрдөг бөгөөд шилдэг технологийг боловсруулах, түүнийг группын хэмжээнд нэвтрүүлэх, ирээдүйн стратегийн ач холбогдол бүхий хүдрийн нөөцийг ашиглах зарчмын өөрчлөлт гаргах арга эрэлхийлэх болон группын хэмжээнд шинэ уурхай, боловсруулалтын тоног төхөөрөмж зохиох, дэд бүтэц хөгжүүлэх гол үүрэгтэй ажилладаг.

Тус бүлэг нь технологийн мэргэжилтнүүдийн үндсэн баг болон тэргүүлэх туршлагыг бий болгох зорилготой хэд хэдэн технологийн төвүүдээс бүрддэг. T&I нь олборлолт, боловсруулалт, хөрөнгийн удирдлага, стратегийн бүтээгдэхүүн төлөвлөлт, төсөл бий болгох болон үнэлгээний үйл ажиллагаанд тогтвортой ахиц дэвшил гаргахаар ажилладаг.

Эрэл хайгуулын бүлэг

Геологийн эрэл хайгуул нь судалгаагаар ашигт малтмалын ордыг илрүүлэх, ангилах, тал талаас шинжлэх тал дээр анхаарч ажилладаг.

Хайгуулын гол зорилго нь ирээдүйд үр ашигтай байж болох эрдэс баялгийн нөөцийг хайж олох буюу худалдан авснаар компанийн нийт үнэ цэнийг өсгөн нэмэгдүүлэхэд оршино. Хайгуулын хөрөнгө оруулалт нь орон нутгийн байрлал эсвэл ашигт малтмалын төрөлд захирагдах биш олдож буй боломж тус бүрийн чанараас шалтгаалдаг.

Рио Тинтогийн Эрэл хайгуулын бүлгэм нь Америк, Австралази (үүнд Хятад, Монгол хамаарагдана) болон Африк-Евроази гэсэн гурван бүсийг хариуцсан нэгжүүдээс бүрддэг. Шинэ төсөл хөгжүүлэх нэгж нь дэлхий даяар шинэ боломжийг хайж бүс нутгийн төвүүдэд геологи, геофизикийн судалгаа болон бизнесийн мэдээлэл, туршлагаар дэмжиж ажилладаг.



Компанийн үйл ажиллагаа уурхайнуудын 90 хувь нь байрладаг Австрали, Хойд Америк болон Европт голлон төвлөрдөг, мөн Өмнөд Америк, Ази, Өмнөд Африкт ч томоохон хэмжээний үйл ажиллагаа явуулдаг.

Хөнгөн цагааны бүлгэм[†]

Хөнгөн цагааны хүдэр болон исэл, хөнгөн цагаан


● Уурхай болон уурхайн төслүүд

■ Уурхайгаас алслагдсан хайлуулах, цэвэршүүлэх болон боловсруулах үйлдвэрүүд

Зэсийн бүлгэм[†]

Зэс, алт болон никель

● Уурхай болон уурхайн төслүүд



Алмааз & Эрдэсийн бүлгэм†

Алмааз, шохой, тальк, титаны давхар
борын исэл, литий

Алмааз

● Уурхай болон уурхайн төслүүд

Эрдсүүд

● Уурхай болон уурхайн төслүүд

■ Хайлуулах, цэвэршүүлэх болон
боловсруулах үйлдвэрүүд

Эрчим хүчний бүлгэм†

Нүүрс, уран

● Уурхай болон уурхайн төслүүд

Төмрийн хүдрийн бүлгэм†

Төмрийн хүдэр, давс

● Уурхай болон уурхайн төслүүд

■ Хайлуулах, цэвэршүүлэх болон
боловсруулах үйлдвэрүүд

†Газрын зурагт зааж үзүүлэв

Тогтвортой хөгжил

Бидний бизнесийн үндсэн зарчим нь эдийн засгийн өсөлт хөгжил, нийгмийн сайн сайхан, байгаль орчны хамгаалал, тогтвортой удирдлагын тогтолцоо зэрэг тогтвортой хөгжлийн шалгуурууд компанийн бүх үйл ажиллагааг тодорхойлдог. Энэ нь бидний нэр хүндийг өндөрт өргөж эрдэс баялаг, санхүүгийн хөрөнгө болон боловсон хүчний нөөцтэй байх боломжийг нээж өгдөг.

Тогтвортой хөгжлийг хангах бидний зорилт нь тогтвортой хөгжлийн бодлогыг бизнесийн төлөвлөгөө, шийдвэр гаргах явцын салшгүй нэгэн хэсэг болгодог юм.

Бид түнш болон оролцогч талуудтайгаа урт удаан хугацааны харилцаа тогтоохыг зорилго болгон ажилладаг бөгөөд энэхүү харилцаа нь харилцан хүндлэл, идэвхтэй түншлэл, урт хугацааны үүрэг амлалтаар тодорхойлогддог. Итгэл баттай сүүринд тулгуурласан харилцаан дээр үндэслэн бий болж, “Рио Тинто”-г эрдэс баялгийн нөөц ашиглах давуу эрхийг олж авах боломжийг батжуулдаг.

Бид ажилтнуудаа компанийн үнэт зүйлс, стратеги, хөгжлийн чигийг ухамсарлан хүлээн зөвшөөрч, ажил үүргээ гүйцэтгэхдээ өөрсдийн бүх мэдлэг боловсрол, чадлаа дайчлан ажиллах боломжтой ажлын орчныг бий болгодог.

Аюулгүй байдал бол манай бүх бизнест эн тэргүүний зүйл юм. Бид ямар ч гэмтлээс урьдчилан сэргийлэх боломжтой гэж итгэдэг. Бидний зорилго бол бүх ажилтнууд маань өдөр бүр ажлаа дуусгаад эрүүл, аюулгүй гэртээ харих явдал юм.

Бид экологийн үр өгөөж, усны менежментийн хариуцлага хүлээж, биологийн олон төрөл зүйлийг хамгаалан, цаг уурын өөрчлөлтийн шийдэлд хувь нэмэр оруулан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгадаг.

Бид бүтээгдэхүүний чанарын удирдлагын хүрээнд металл, эрдэс баялгийн найдвартай, аюулгүй үйлдвэрлэх, хэрэглэх, дахин боловсруулах, хаягдал зайлуулах зэрэгт хяналт тавьдаг.

Хариуцлага, Хүндлэл, Хамтын Ажиллагаа, Шударга байдал гэсэн Рио Тинтогийн үнэт зүйлсүүд нь бидний бизнесийн зарчим, бодлого, стандартаар илэрхийлэгддэг. Бид энэ бүгдийг бизнесийн ёс зүйн дүрэм “*Бидний ажилладаг арга барил*” нэртэйгээр дэлхий даяар хэрэгжүүлэн ажилладаг. Манай үнэт зүйлс нь бидний үйл ажиллагааны эдийн засаг, нийгэм, байгаль орчны нөлөөллийг зохицуулах болон бизнесийн удирдлагын үндэс суурь нь болдог.

Рио Тинтогийн удирдан явуулдаг бүх бизнест “*Бидний ажилладаг арга барил*”-ыг баримталдаг бөгөөд үүнийгээ өдөр тутмын үйл ажиллагаандаа баримталдаг өндөр стандартаар дамжуулан хэрэгжүүлдэг. Бид өөрсдийн бизнесийн түншүүдээ өндөр стандарт баримтлахыг шаарддаг бөгөөд манай бодлогуудтай нийцсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд нь бүх талаар дэмжиж ажилладаг.

Баруун талд

Бид харилцан хүндлэл, идэвхтэй түншлэл, урт хугацааны үүрэг амлалтаар тодорхойлогдсон урт удаан хугацааны харилцаа бий болгохыг зорилго болгон ажилладаг.





Мэдээллийн хуудас

Компанийн тухай

Хөнгөн цагаан

Зэс

Алмааз

Эрчим хүч

Үйлдвэрлэлийн эрдэс

Төмрийн хүдэр

Технологи шинэчлэлт

Хайгуул

Рио Тинто плс
2 Eastbourne Terrace
London W2 6LG
United Kingdom

У +44 (0)20 7781 2000

Рио Тинто Лимитэд
120 Collins Street
Melbourne, Victoria 3000
Australia

У +61 (0)3 9283 3333

www.riotinto.com